



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/93

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Авто замын засвар, шинэчлэл /Ховд, Чандмань сум/ ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж.Батсайхан - "Тогтвортой амьжиргаа-3" төслийн зохицуулагч

Гишүүдэд: Х.Ганболд - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

П.Эрдэнэ-Очир - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Энхтайван - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ж.Батсайхан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020 тг А/93 Чх
02 00533